



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 8/116

Дэлгэрхаан сум

**Хиймэл хөв цөөрөм хийхэд
зардал гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 3.6.4 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 сарын 26-ны 34 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалаас төсөвлөсөн ажлын төлөвлөгөөний дагуу зарцуулж, Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, усан хангамж, орчинг сайжруулах зорилгоор хиймэл хөв цөөрөм бий болгох ажилд зардал гаргасугай.

2.Хиймэл хөв цөөрөм хийх ажилд шаардлагатай нийт 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Аварга-Дэлгэрхаан нөхөрлөлүүдийн холбоо төрийн бус байгууллагын дансанд шилжүүлсүгэй.

3.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдэж буй ажлыг чанартай зохион байгуулж, ажлын тайлан, судалгааг фото зургаар баталгаажуулж, тайлан ирүүлэхийг “Аварга-Дэлгэрхаан” нөхөрлөлүүдийн холбоо төрийн бус байгууллагын тэргүүн (Н.Баттөр)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо) нарт даалгасугай.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



2325010265



Life

$\frac{1}{2}$ 二
 $\frac{1}{3}$ 三
 $\frac{1}{4}$ 四

L

مسلمین کے لیے